

Өлгий сумын ЗДТГ-ын 11-р сарын 30-с эхлэн 7 хоногт хийсэн ажлын мэдээлэл

2018-12-06

- ЗААлбанаас сумын ээлжит ИТХ-ын чуулганы бэлтгэл ажлыг хангаж, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2018 оны үндсэн чиглэлийн биелэлтийг гарган бэлтгэв.
- Аймгийн прокурорын газраас ирүүлсэн албан мэдэгдлийн дагуу худалдаа үйлчилгээний цэг салбаруудад хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар албан шаардлага хүргүүлэн ажилласан.
- Хүүхэд үрчлэн авах 5 иргэний материалыг хүлээн авч, дүгнэлт гаргаж, өгч сумын Засаг даргын захирамжийг гаргалаа.
- 2018 оны жилийн эцсийн хүн ам, малын тооллогын бэлтгэл ажлыг хангаж 2018 оны 12-р сарын 07-ны өдрөөс эхлэн тооллогоонд БЗДарга болон багийн нийгмийн ажилтан, албан хаагч нарыг тооллогоонд гаргаж ажиллаж байна.
- Аймгийн цэргийн штабт багийн засаг дарга нар сургалтанд хамрагдав.
- Зам талбайн цэвэрлэгээ хийж 5 тн хогийг хогийн цэгт хүргэв.
- Гэрэлтүүлгийн засвар үйлчилгээг хийж шөнийн гэрэлтүүлгээр хангаж ажиллаж байна.
- Багийн засаг дарга нартай хамт хуваарийн дагуу нохой устгах ажил хийж 21ш нохой устгасан болно.
- Хөдөлмөр Халамж Үйлчилгээний газраас олон нийтийн хамарсан ажлын хүрээнд 20 хүн авч хогийн цэгийн орчимын цэвэрлэгээ хийлгэж байна. /ХТАлба/

ӨЛГИЙ СУМЫН ЗДТГ